

## **ХОЛБООНЫ 2017 ОНЫ 2-Р УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Энэ улиралд Удирдах зөвлөл 6 удаа хуралдаж, цаг үеийн тулгамдсан асуудлуудыг хэлэлцэж 1 тогтоол, Ерөнхий нарийн бичгийн даргын 2 тушаал гарсан байна.

2017 оны 2-р улиралд Холбооноос явуулсан албан бичгийн тоо 17; Холбоонд ирсэн албан бичгийн тоо 10 бүртгэгдсэн байна.

2017 оны 1-р улирлын тайланг УЗ-ийн 2017 оны 4-р сарын ээлжит хурлаар танилцуулж гишүүдэд илгээв.

УЗ-ын нөхөн сонгууль явуулсан бөгөөд УЗ-ийн ердийн гишүүнд 3 хүн, хараат бус гишүүнд 2 хүн нэрээ дэвшүүлснээс Холбооны УЗ-ийн гишүүдийн олонхийн саналаар ердийн гишүүнээр "Эм Ай Си Си ҮЦК" ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Ачит-Эрдэнэ, хараат бус гишүүнээр УИХ-ын тамгын газар, УИХ-ын гишүүний зөвлөх Ж.Цэдэнрагчаа нар сонгогдлоо.

### **Холбооны дотоод үйл ажиллагааны чиглэлээр**

03 дугаар сарын 22-нд СЗХ-ны Үнэт цаасны газрын даргын үүрэг гүйцэтгэгч Т.Цэрэнбадрал албаны хүмүүсийн хамт Холбоо болон Үнэт цаасны компаниудаас нийт 13 хүнийг хүлээн авч уулзлаа. Уг уулзалтаар ҮЦК-уудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх тухай, Төлбөр тооцооны данс нээхтэй холбоотой асуудлуудын тухай, Хамтын ажиллагааны тухай болон бусад цаг үеийн асуудалаар санал бодлоо солилцсон.

Холбоо нь энэ оны 04 дүгээр сард Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим/МҮХАҮТ/-д гишүүнээр элсэх хүсэлтээ өгч гишүүнээр элссэн бөгөөд 6 дугаар сарын 02-ны өдөр МҮХАҮТ-ийн гишүүний гэрчилгээ гардуулах ёслолын ажиллагаа боллоо. Холбоо нь МҮХАҮТ-ийн гишүүн болсноор МҮХАҮТ-ын гишүүдээр дамжуулан хөрөнгийн зах зээлийг сурталчлах, тэдний мэдлэгийг өргөжүүлэх, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх талаар ажиллахаар зорьж байна.

04-р сарын 07-нд Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын үйлчилгээг нэг цэгээс иргэдэд хүргэх, үйл ажиллагааг нь олон түмэнд сурталчлах, импортыг орлох бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэгч үндэсний үйлдвэрүүдийг дэмжих, хамтарч ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, төр-хувийн хэвшлийн түншлэлийг идэвхжүүлэх замаар эдийн засгийн хүндрэл бэрхшээлийг даван туулах ажил хэрэгч хамтын ажиллагааг өрнүүлэх зорилготой "Төрийн өмчийн менежмент ба нийгмийн хариуцлага-2017" сэдэвт өдөрлөгт оролцлоо.

"Хөрөнгө оруулагч үндэстэн" чуулга уулзалт 4-р сарын 22-23-ны өдрүүдэд "Corporate Convention Centre"-д боллоо. Тус чуулга уулзалт Хөрөнгө оруулалт, Хувьчлал, Санхүү ба Технологи, Гарааны бизнес гэсэн үндсэн дөрвөн сэдвийг онцолсон юм. Хөгжиж буй хөрөнгийн зах зээлийг идэвхжүүлэх зорилгын хүрээнд зохион байгуулсан энэхүү чуулга уулзалт иргэдэд санхүүгийн боловсрол олгохоос гадна санхүүжилт эрэлхийлж буй бизнес эрхлэгчдийг хөрөнгө оруулагчтай холбох мөн дэлхийн шилдэг хөрөнгө оруулагчид өөрсдийн туршлагаа энэ үеэр хуваалцаж, оролцогчид зах зээлийн чиг хандлагын талаар мэдээлэл солилцов.

Холбооноос эрх авсан мэргэжилтнүүдийн болон бусад салбарын оролцогч байгууллагуудын цахим шуудангийн жагсаалтыг бий болгож Холбооны долоо хоног бүрийн мэдээллийг илгээж эхэлсэн.

Холбооноос Анхан болон дунд шатны сургалтуудыг зохион байгуулах талаар “Монголын Хөрөнгийн бирж” ТӨХК-ын удирдлагатай уулзаж санал бодлоо солилцов.

Холбооноос компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга нарт зориулсан “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ”-ын гэрчилгээ олгох сургалтыг 2017 оны 4,5 сард зохион байгуулж 23 хүн сургалтад хамрагдлаа.

Холбооны оффисын байрны түрээсийг 05 дугаар сараас эхлэн 20 хувиар бууруулав.

Мөн Холбооны Удирдах Зөвлөлийн дарга Б.Өлзийбаяр 05-р сарын 03-нд Блүүмберг ТВ-ийн зочны хөтөлбөрт ОУВС-ын талаар болон зах зээлийн цаг үеийн асуудлаар ярилцлага өглөө.

Холбооны вэб сайтад хоёр удаа нэмэлт өөрчлөлт хийв.

06 дугаар сарын 22-нд СЗХ-ны Үнэт цаасны газрын дарга Б.Лхагвасүрэн Холбооны удирдагуудыг хүлээн авч уулзсан бөгөөд уг уулзалтаар СЗХороо болон Холбооны цаашдын хамтын ажиллагааны талаар санал бодлоо солилцлоо.

Энэ оны 06-р сарын 28-нд "Монгол улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр" сэдэвт хэлэлцүүлэгт холбооны зүгээс УЗ-ийн гишүүн Ч.Жаргал оролцов.

### **Гишүүн байгууллага, мэргэжилтнүүдийн эрх ашиг болон чадавхийг сайжруулах чиглэлээр**

Хувьцаат компаниудтай танилцах ээлжит аяллын хүрээнд 06 дугаар сарын 16-ны өдөр "Шарын гол" ХК-иар аяллаа. Шарын гол ХК-ийн шинээр байгуулагдсан угаах үйлдвэр, нүүрсний уурхайтай танилцав.

Хороо Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЛСА/-тай хамтран "Үнэт цаасыг олон нийтэд санал болгох үйл ажиллагаа болон давхар бүртгэл" сэдэвт 3 дахь удаагийн семинарыг 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдөр зохион байгууллаа. Уг семинараар үнэт цаасыг олон нийтэд санал болгох үйл ажиллагаа болон давхар бүртгэлийн ач холбогдол, Япон улс болон бусад улсын хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татах боломж, эдгээр улсуудын үнэт цаасны бүртгэлийн шалгуур, шаардлага, зохицуулалтын орчны харьцуулсан судалгааг нарийвчлан авч хэлэлцлээ.

### **Хөрөнгө оруулагчдын эрх, ашиг болон хөрөнгийн зах зээлийн тогтвортой хөгжлийн чиглэлээр**

Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа явуулдаг 5 байгууллагын хооронд хамтран ажиллах санамж бичигт өнгөрсөн онд гарын үсэг зурсан. Энэхүү санамж бичгийн хүрээнд

байгууллага тус бүр өөрийн компанийн бүтэц болон 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөгөө танилцуулж цаашид хэрхэн хамтарч ажиллах талаар санал бодлоо солилцож зах зээлийн дэд бүтцийн асуудлын нэг болох Т+3 төлбөр, тооцооны системд шилжих асуудлаар “DVP ажлын хэсэг” байгуулан ажиллахаар болов. Уг ажлын хэсгээр дараах асуудлуудыг хэлэлцэв.

Үүнд: 1-рт Дэлхийн банкны зөвлөх Давид Вайгийн бэлтгэсэн илтгэлийг АТТ-гээс танилцуулсан 2-рт БДК-иудыг хүлээн авч, төлбөрийн баталгааны сангийн журмын төсөлтэй холбоотой санал хүсэлтийг сонсож хэлэлцэв 3-рт DVP систем рүү шилжих шаардлага болон DVP системийн талаар "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-аас танилцуулга хийв 4-рт АТТ-ийн холбогдох журмууд дээр ажиллаж мөн Сангийн яамтай DVP системийн асуудлаар УЗ-ийн дарга Б.Өлзийбаяр, ЕНБДарга Ц.Хуяг нар уулзалт хийлээ.

Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төслийн талаар холбооны зүгээс зохих газруудад албан тоот хүргүүлж тус хуулийн төслийн талаар саналаа өглөө.

Мөн энэхүү хуулийн төслийн талаар Гадаадын банкны монгол дахь төлөөлөгчийн газар /Bank of China, ING, MUFG/ -ын удирдлагуудтай уулзаж санал бодлоо солилцож, УИХ-ын гишүүдэд “Хөрөнгө оруулалтын банкны тухай хууль”-ийн төсөлд саналаа хүргүүлсэн ба уг асуудлаар Эдийн засгийн байнгын хорооны гишүүн З.Нарантуяатай Холбооны төлөөлөлтэй уулзалт хийв. Мөн уг хуулийн төслийн талаар сэтгүүлчдэд цаг үеийн талаар мэдээлэл өгч хэвлэлийн бага хурал зохион байгуулсан ба холбооны саналыг хүлээн авч хуулийн төслийг яаравчлан батлуулахааргүй болсон.

Азийн хөгжлийн банкнаас “Монгол Улсын санхүүгийн салбарын хөгжил, тогтвортой байдлыг дэмжих төсөл”-ийн хүрээнд Монголбанктай хамтран “Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах” бүрэлдэхүүн хэсгийг хэрэгжүүлэх “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг байгуулан, олон улсын зөвлөх сонгон ажиллаж байна. Уг төслийн хүрээнд санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн судалгаа хийгдэж, үүний дагуу зөвлөмж гаргасныг “Монгол Улс дахь санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль, эрх зүй зохицуулалтын өнөөгийн орчин ба өөрчлөн сайжруулах зөвлөмж” үндэсний хэлэлцүүлгийн үеэр танилцууллаа. Энэхүү хэлэлцүүлэг 5 дугаар сарын 26-ны өдөр болсон бөгөөд хэлэлцүүлгийг Монгол банк зохион байгуулж, Санхүүгийн зохицуулах хороо, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар, Монголын банкны холбоо, Банк санхүүгийн академи, Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо болон бусад мэргэжлийн холбоод оролцлоо. Зөвлөмжид банкны харилцагч буюу хэрэглэгчийг хамгаалах хуулийн зохицуулалттай болох, хяналт шалгалт хийдэг болох, тайлан мэдээг авдаг болох, хяналт шалгалтын бүтэц бий болгон ажиллах шаардлагатай байгаа тухай тусгажээ.

Монгол Улсад анх удаа санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах чиглэлээр хэрэгжиж буй энэхүү төсөл нь нийт санхүүгийн салбарыг хамарч байгаа бөгөөд төслийн үр дүнд Монголбанк, бусад эрх бүхий байгууллагын санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах чадавхыг бэхжүүлэх, Монгол Улсад санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах тогтолцоо сайжруулах, санхүүгийн салбар дахь маргааныг шүүхийн бус замаар шийдвэрлэх тогтолцоог бий болгоход дэмжлэг үзүүлэх зорилготой ажиллаж эхлээд байна.

Холбооны Удирдах зөвлөлийн дарга Б.Өлзийбаяр NTV-д Бондын талаар, 4-р сарын 11-нд Монголын үндэсний телевизийн "Цагийн хурд" нэвтрүүлэгт Хадгаламжийн хүүгийн орлогод ногдуулах татварын асуудлаар болон 4-р сарын 14-нд "Эрдэнэс Таван толгой" ХК-ийн талаар тус тус ярилцлага өглөө.

### **Гадаад дотоодын хамтын ажиллагааны чиглэлээр**

Холбооноос CFA Институттэй 4-р сарын 12-ны өдөр CFA Институттэй цахим уулзалт /conference/ хийсэн ба уулзалтанд Удирдах зөвлөлийн дарга Б.Өлзийбаяр, Ерөнхий Нарийн Бичгийн Дарга Ц.Хуяг, Ёс зүйн хорооны дарга Г.Мөнх-Эрдэнэ, CFA С.Тунгаа, CFA Institute-ээс Jon Stokes, Glenn Doggett, Irene Cheung нар оролцож CFA Институтгийн Asset Manager Code стандартыг Монголд хэрэгжүүлэх талаар санал бодлоо солилцлоо. Мөн хоёр байгууллагын хамтын ажиллагааны талаар ярилцав.

Үүний дагуу CFA Институттэй нягт холбогдож хамтын ажиллагаагаа өргөжүүлэх үүднээс 2017 оны 06-р сарын 27-нд МҮЦАЭХ болон Монголын Санхүүгийн Шинжээчдийн нийгэмлэг нь Итгэмжлэгдсэн Санхүүгийн Шинжээчдийн Нийгэмлэг (CFA institute)-тэй хамтран Хөрөнгө Оруулалтын салбар дахь Мэргэжлийн ёс зүйн ач холбогдол сэдвийн хүрээнд нэг өдрийн арга хэмжээг зохион байгуулж хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурав. Энэхүү хамтын ажиллагаанд Итгэмжлэгдсэн Санхүүгийн Шинжээчдийн Нийгэмлэг(CFA institute)-ээс Nick Pollard, /Managing Director/, Thomas Ma /Director of Government and Regulator Relations/ нар хүрэлцэн ирсэн.

БНСУ-ын Санхүүгийн хөрөнгө оруулалтын холбоо /KOFIA/-ны ерөнхийлөгч болон тус Холбооны гишүүн байгууллагуудын төлөөлөл Монгол улсад 2017 оны 06 дугаар сарын 12-17-ний өдрүүдэд айлчлал хийв. Уг айлчлалын үеэр Монголын Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо болон Солонгосын Санхүүгийн хөрөнгө оруулалтын холбоо хөрөнгийн зах зээлийн хөгжил болон хөрөнгө оруулалтыг дэмжин хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа.

Хамтын ажиллагааны хүрээнд бодитой төслүүд дээр хөрөнгө оруулах, манай зах зээлийн мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлэх талаар нэлээд ажил хийгдэхээр төлөвлөгдөөд байна.

Уг айлчлалаар Санхүүгийн хөрөнгө оруулалтын холбоо /KOFIA/-ны ерөнхийлөгч Hwang, Young-Key (YK) болон Yoo, Jae Eun /Chairman, Kukje Asset Trust/, Choi, IgJongn /CEO, Korea Trust/, Chung, Sun iln/CEO, KB Real Estate Trust/, Choi, Byoung-Gil /CEO, Mugunghwa Trust/, Lee, Chang Hee /CEO, Hana Asset Trust/, Kim, Kyoo Chul /CEO, Korea Asset In Trust/, Jang, Sok-Hwan /Senior Director, Korea Financial Investment Association/, Lim, Woongjin /Manager, Korea Financial Investment Association/ нар хүрэлцэн ирсэн.

Монголын барилгын үндэсний ассоциаци болон Үл Хөдлөх Хөрөнгө Зуучлагчдын Нэгдсэн Холбооны удирдлагуудтай уулзаж Монголын үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн талаар мэдээлэл авлаа.

Энэ оны 05-р сарын дундуур Холбооны УЗ-ын дарга болон ЕНБД нар БНХАУ-ын Хибэ мужид зохион байгуулагдсан хөрөнгө оруулалтын форумд оролцов.

Солонгосын банкны холбоо болон Монголын банкны холбоо хоёрын хамтран зохион байгуулсан “Монгол-Солонгосын Санхүүгийн Форум”-д оролцсон.

“ҮЦТХТ” ХХК-ийн урилгаар Солонгосын Үнэт Цаасны Хадгаламжийн байгууллага /KSD/-ын төлөөллүүд энэ оны 7 дугаар сарын 16-17-ны өдрүүдэд Монгол улсад ажлын айлчлалаар хүрэлцэн ирсэн бөгөөд айлчлалын үеэр Солонгос улсын хадгаламжийн төвийн дэргэдэх сан /KDS/-гийн төлөөллүүдийг Холбооны байранд хүлээн авч уулзлаа. Уг уулзалтаар Санхүүгийн мэдээллийг олон нийтэд түгээх зорилгын хүрээнд уулзсан бөгөөд KDS-ийн зүгээс байгууллагынхаа үйл ажиллагаагаа танилцуулсан. Мөн тус байгууллагын зүгээс Солонгосын хөрөнгийн зах зээлийг таниулах ажлын хүрээнд эхний шатанд Монголын Хөрөнгийн Зах Зээлийн зохицуулагч байгууллагуудын мэргэжилтнүүдийг Солонгос хэлний сургалтад үнэгүй хамруулахаар болсон бөгөөд Холбооноос 5 хүн уг сургалтад хамруулахаар болсон.

### **Хууль, эрх зүйн чиглэлээр**

DVP ажлын хэсгийн хүрээнд Ди ви пи системийг судалж холбогдох байгууллагууд харилцан мэдээлэл солилцож тус үйл ажиллагааны дагуу Арилжааны төлбөр тооцооны төвийн холбогдох журмуудад санал солилцож ажиллав.

### **Мэргэшлийн эрх олгох сургалтыг сайжруулах чиглэлээр**

06 дугаар сарын 30-ны байдлаар Хобооноос Үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрх авсан /эрх нь хүчинтэй байгаа/ нийт 577 мэргэжилтэн байгаагаас Хөрөнгө оруулалтын зөвлөхийн эрхтэй 451 мэргэжилтэн, Үнэт цаасны зуучлалын эрхтэй 126 мэргэжилтэн байна.

Санхүүгийн зохицуулах хороо, Холбоо болон Жайкагийн төслийн баг хамтран Өөрийгөө зохицуулах байгууллагын чадавхыг сайжруулах ажлын хүрээнд Холбооны эрх олгох сургалтад зориулж ном гаргахаар ажиллаж байгаа билээ. Энэхүү ажлын хүрээнд гурван талт уулзалтуудыг хоёр удаа зохион байгуулж тодорхой санал солилцож ажилласан ба энэ оны долдугаар сард тус номын агуулгад Холбооноос оруулах сургалтын материалыг бэлдэж төслийн багийнханд хүргүүлсэн.

Түүнчлэн тус хугацаанд Холбооны удирдлага Жайкагийн төслийн багийнхантай уулзалт хийж үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрх олгох сургалтын хөтөлбөрийг шинэчлэх талаар санал бодлоо солилцож зохих өөрчлөлтийг хийж энэ оны эхний сургалтыг зохион байгуулахаар болсон.

Холбооноос зохион байгуулдаг Үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрх олгох, аттестатчилах сургалтыг 2017 оны 05-р сарын 22-оос 06-р сарын 02-ны хооронд зохион байгууллаа. Сургалтад Хөрөнгө оруулалт болон үнэт цаасны зуучлалын чиглэлээр 55, Аттестатчилах буюу эрхээ сунгуулах 41 мэргэжилтэн сургалтад хамрагдсанаас 93 хүн эрхээ сунгаж, шинээр эрх авлаа.

Эрхээ авсан шинэ мэргэжилтнүүд болон аттестатчилах сургалтад хамрагдаж эрхээ сунгуулсан хүмүүсийг 2017 оны 06-р сарын 27-нд тангараг өргүүлэх ёслолыг амжилттай зохион байгуулав.

### **Төрийн өмчийн хувьчлалын чиглэлээр**

Холбооны Удирдах зөвлөлийн дарга Б.Өлзийбаяр болон Удирдах зөвлөлийн гишүүн Д.Ачит-эрдэнэ нар Холбооны Ерөнхийлөгч УИХ-ын гишүүн Д.Цогтбаатар гишүүнтэй Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төслийн талаар мэдээлэл солилцож, "Эрдэнэс Таван толгой" ХК-ийн хувьцааг хөдөлгөх талаар Холбооны төлөвлөгөөг танилцуулав.

Стратегийн ордуудын 10 хувийг дотоодын хөрөнгийн бирж дээр хувьчилж үнэт цаас гаргаж арилжаалах, иргэдийн бизнесийн боловсролыг бодлогоор дэмжиж хөгжүүлэх шаардлагатай байгаа талаар санал бодлоо илэрхийллээ.

Эрдэнэс Монгол ХХК-аас Холбооны удирдлагуудыг хүлээн авч уулзсан бөгөөд Холбооны зүгээс Төрийн өмчийн хувьчлалын талаар болон Эрдэнэс Таван толгой ХК-ийн хувьчлалын талаар санал бодлоо солилцлоо.

~ ~ ~

**МҮЦАЭХолбооны ажлын алба**  
**2017.07.31**